



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/533

Зуунмод

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтанбулаг сумын Сумт багийн иргэн Л.Отгонцэрэнгийн 5 ханатай бүрэн тавилгатай гэр 2021 оны 07 дугаар сарын 27-ны 16:00 цагийн орчимд, Баянчандмань сумын Замт багийн иргэн Г.Ариунболдын 7x8 метр хэмжээтэй орон сууцны байшин, суудлын автомашин, граж бүрэн шатсан тул иргэн Л.Отгонцэрэн, Г.Ариунболд нарын гэр бүлд тус бүр 4.730.000 (дөрвөн сая долоон зуун гучин мянга) төгрөгийн үнэ бүхий гэрийг буцалтгүй тусламжаар олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах 9.460.000 (есөн сая дөрвөн зуун жаран мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (С.Магнайбаяр)-т, шилэн дансанд байршуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (Э.Бүжинлхам)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР